



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2022 оны ээлжит 08 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 08 дугаар хуралдаан 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) хэлбэрээр болов.

Энэхүү хуралдаанаар "Сансрын холбоонд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага" баримт бичгийн төслийн тухай; "Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт /FM/ ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага"-ын баримт бичгийн төслийн тухай; "Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн зохицуулалтын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааны тайлан"-гийн танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай) зэрэг нийт 9 асуудлыг хэлэлцсэн. Энэхүү хуралдаанаар нийт хорооны 5 тогтоолыг баталж, хуралдааны 2 тэмдэглэлээр хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэл өгсөн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 12 тоот тогтоол, 2014 оны 31 тоот тогтоолоор баталсан Сансрын холбоонд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагатай холбоотой 2 баримт бичгүүд; зохицуулах хорооны 2004 оны 12 тоот тогтоол, 2007 оны 07 тоот тогтоол, 2012 оны 14 тоот тогтоол, 2019 оны 15 тоот тогтоол, 2020 оны 25 тоот тогтоолоор батлан, нэмэлт өөрчлөлт оруулсан Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт /FM/ ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагын баримт бичгүүдийг Улаанбаатар хот, орон нутагт зэрэг тус тусын дэд чиглэлээр батлан хүчин төгөлдөр мөрдөж байна.

УИХ-аар 2019 онд Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулан баталснаар дээрх баримт бичгүүдийг салбарын суурь хуулиуд болон Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, улмаар радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагуудын шинэчлэн батлах шаардлага гарсан болно.

Иймээс зохицуулах хорооны 2022 оны ээлжит 08 дугаар хуралдаанд Радио давтамж хяналт, зохицуулалтын газраас нэгтгэн боловсруулсан "Сансрын холбоонд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага" баримт бичгийн төслийн тухай болон "Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт /FM/ ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага"-ын баримт бичгийн төслийн тухай танилцуулга; хорооны тогтоолын төсөл, баримт бичгийн төслийн талаар уулзалт хэлэлцүүлгийн үр дүн болон албан тоотоор ирүүлсэн саналын товчоо, нөлөөллийн шинжилгээг тус тус хэлэлцэв. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ зүйлийн 5¹.1.2 дах

заалтыг тус тус үндэслэн 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 37 тоот “Сансрын холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай” хорооны тогтоолыг хавсралтын хамт баталсан болно. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 12 тоот тогтоол, 2014 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 31 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгов. Энэхүү баримт бичгийг баталснаар хууль тогтоомжид заасан ХХЗХ-ны бүрэх эрх болон Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 5¹.1.2¹ заалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулах сансрын холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг тодорхойлох боломжийг бүрдүүлж байна. Уг тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд шинэчлэн хянуулж бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/1266 албан тоотоор /2022-09-12/ хүргүүлсэн. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 5948 тоот улсын бүртгэлд 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр бүртгүүлэн баталгаажуулсан. Бүртгүүлсэн тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.crc.gov.mn)-д тус тус байршуулсан.

Хорооны 2022 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ зүйлийн 5¹.1.2 дах заалтыг тус тус үндэслэн “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 38 дугаар тогтоол, хавсралт баримт бичгийн батлан шийдвэрлэсэн. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан ХХЗХ-ны 2004 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 12 тоот тогтоол, 2007 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 07 тоот тогтоол, 2012 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 14 тоот тогтоол, 2019 оны 04 сарын 29-ний өдрийн 15 тоот тогтоол, 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгов. Баримт бичгийг баталснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлсон Хэт богино долгионы (FM) радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, техникийн нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан шинээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/1269 албан тоотоор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 5949 тоот улсын бүртгэлд 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр бүртгүүлэн баталгаажуулсан.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 8 дугаар хуралдаанаар тус хорооны ЗЗҮТЗГ-аас боловсруулсан “Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн зохицуулалтын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааны тайлан”-гийн танилцуулга, санал зөвлөмж, дүгнэлт болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар авч хэлэлцээд, 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 09 дүгээр “Судалгааны зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” хуралдааны тэмдэглэлийг баталж, холбогдох хугацаатай үүрэг даалгавар, удирдамж

¹ Радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих.

чиглэлийг хэрэгжүүлэхийг холбогдох бүтцийн удирдлага нэгжид даалгав. Тэмдэглэлд, энэхүү судалгааны зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтийг хангах, цаашид байгууллагын болон зохицуулалтын үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэхэд анхаарч дараах чиглэлээр арга хэмжээг авч ажиллахыг Ажлын алба /Д.Сэрээдорж/, Зах зээл үнэ тарифын зохицуулалтын газар /Д.Ариунболд/, холбогдох газрын дарга нарт үүрэг болгов. Үүнд: Судалгааны үр дүн, гарсан санал зөвлөмж, дүгнэлт болон үзүүлэлт, холбогдох чиглэлээр газар бүр дүн шинжилгээ хийх, буурсан үзүүлэлт, зохицуулалтын шалтгааныг тогтоох, хэрэгжүүлэх ажлын нэгдсэн хугацаа бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллах; Судалгааны үр дүн, санал зөвлөмжийг олон нийт, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт сурталчлах, 2022 оны төвийн бүсийн зөвлөгөөнд танилцуулах; Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд судалгааны үр дүнтэй холбоотой хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ /хүрэх үр дүн ба үзүүлэлтүүд, хэлэлцүүлэг, сургалт, байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, сурталчилгаа г.м/, төсөв хөрөнгийг тусгах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; Хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дугаартайгаа шилжих арга хэмжээний талаар ажлыг 2023 оны төлөвлөгөөнд тусгах, эрчимжүүлэх; Шүүхийн гомдол, маргаантай холбоотойгоор хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх зэрэг болно.

Тус хорооны 2022 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар тусгай зөвшөөрөл олгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 3 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тусгай зөвшөөрлийн олголт, сунгалт, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс гарсан саналыг үндэслэн 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 10 дугаар “Тусгай зөвшөөрлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” хуралдааны тэмдэглэлийг батлав. Тэмдэглэлд зааснаар, цаашид тусгай зөвшөөрлийн талаарх үнэлгээний санал дүгнэлтийг хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхдээ хүсэлт гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, гэрээний үүргийн биелэлт, зохицуулалтын үйлчилгээний хөлс, радио давтамж, дугаарлалтын төлбөрийн үлдэгдэлтэй эсэх асуудал, тус хорооноос баталсан захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам болон хорооны шийдвэрийг хэрхэн биелүүлж ажиллаж байгаа тухай тайлан мэдээлэл зэргийг шүүхийн маргааны хамт танилцуулж ажиллахыг Ажлын алба /Д.Сэрээдорж/, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/, Хуулийн хэлтэс /Т.Ууганбат/, холбогдох газар, хэлтэст тус тус үүрэг чиглэл болгов. Тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д даалгав.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 3 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 3 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 39 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдэд 7 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;

- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 40 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 41 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2022-09-04